

БАТЛАВ.
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ГҮЙЦӨТГӨХ ЗАХИРАЛ



Б.МӨНХБАТ

**ХОВД АЙМГИЙН ТӨВ БАЙРНЫ ДОТОР ИХ
ЗАСВАРЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**
/ *Л.ХУУДАС* /

ТАНИЛЦСАН:

А.ГАНТУЛГА
ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

Ц.ОДХҮҮ
СТРАТЕГИ, САНХҮҮ БОРЛУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

БОЛОВСРУУЛСАН:

Н.ИЧИНХОРЛОО
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

2024 ОН


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.01.17.

1. **Барилга байгууламжийн байршил:** Ховд аймаг, Жаргалант сум, 12-р баг, Заны 2-р гудамж, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн салбарын төв байр.
2. **Ажлын зориулалт:** Барилгын дотор их засварын ажил
3. **Барилгын ерөнхий үзүүлэлт :** 1976 онд ашиглалтанд орсон, холбооны үйлчилгээний зориулалт бүхий угсармал цутгамал бетон суурьтай, 640мм -ын блок ханатай, ус дулааны инженерийн шугам сүлжээнд холбогдсон, зоорийн давхар бүхий 2 давхар барилга. 1,2-р зэргийн туслах дам нуруунуудтай, шал тааз нь хучилтын хавтан хийцлэлтэй , шувуу нуруун дээвэртэй, цонх нь модон рамтай 2 давхар, модон хаалгануудтай
4. **Гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага:**
 - 4.1. Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, БНБД стандарт шаардлагад нийцүүлэн, технологийн дагуу, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
 - 4.2. Барилгын ажилд шаардагдах материал, тоног төхөөрөмж нь Монгол улсын стандарт, чанарын шаардлага хангасан байх ба захиалагчаар хянуулна. (Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйл заалтууд, 40.1.20)
 - 4.3. Гүйцэтгэгч нь ажиллагаатай байгаа техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг алдагдуулахаас сэргийлж зай тэжээл, тоног төхөөрөмжийн өрөөг түр битүүмжлэх, тоос шороо доргилтоос хамгаалах арга хэмжээг урьдчилан авна. Ажил гүйцэтгэх явцад кабель таслах болон тоног төхөөрөмжид гэмтэл саатал гаргасан тохиолдолд үүссэн хохирлыг бүрэн хариуцна.
 - 4.4. Ажлыг гүйцэтгэхдээ тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж байгаа бусад байгууллагуудад саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах шаардлагатай.
 - 4.5. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах ба үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Барилга угсралтын ажилд мөрдөх аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар БД 12-101-05-ийг хангаж ажиллана.
 - 4.6. Галын аюулгүй ажиллагааны БНБД 21.02.02, БНБД 21.01.02 дүрэм журам, стандартыг хангасан байна.
5. **Барилгын ажил болон гүйцэтгэгчид тавигдах бусад шаардлага:**
 - 5.1. Засварын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-10-05 (Заслын ажил), БНБД 31-08-05 (Дуу, дулаан тусгаарлалтын ажил) болон бусад шаардлагатай норм стандартыг мөрдлөг болгоно.
 - 5.2. Засварын ажлыг өгөгдсөн ажлын тоо хэмжээ болон ажлын зургийн дагуу сайн чанарын материал ашиглан чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.
 - 5.3. Хаалга цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, амалгаа хийхдээ MNS6266:2011 стандартыг мөрдөнө
 - 5.4. Дотор хананд сайн чанарын эмульсэн будаг бт-177 ашиглана. (галаас хамгаалах)
 - 5.5. Ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
 - 5.6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
 - 5.7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, фото зургаар баталгаажуулсан байна.

6. Барилгын одоогийн зохион байгуулалтын зураг.

1-р давхрын план зураг




Тодорхойлолт	
1	Монгол шуудан нягтлан 14.9м2
2	Монгол шуудан 12.11м2
3	Монгол шуудан 33.23м2
4	МЦХ Нягтлан, Нэрвэ 20.7м2
5	МЦХ жижиг өрөө 49.6м2
6	МЦХ Нарийн бичиг 12.8м2
7	МЦХ Даргын өрөө 22.7м2
8	Гэр бүлийн радио 10.8м2
9	Хоосон өрөө 12.6м2
10	Мобиком склад 16.8м2
11	МХС инженерүүдийн өрөө 19.8м2
12	Мобиком 18м2
13	МЦХ Уйлалтгажээний заал 56.22м2
14	Түц машин байрлах заал 45.6м2
15	Монгол шуудан заал 29.17м2
16	Монгол шуудан заал 9.8м2
17	Монгол шуудан нэрвэ 17.7м2
18	Монгол шуудан Склад 17.16м2
19	Коридор 31.8м2

2-р давхрын план зураг



Тодорхойлолт	
1	МХС Хурлын өрөө 37.2м2
2	МХС КШИ өрөө 12м2
3	МХС ЕИ өрөө 25м2
4	МХС Нягтлан өрөө 22.84м2
5	МХС Дарга өрөө 23.2м2
6	МХС Нэрвэ, бичиг хэргэ 11.2м2
7	МХС 00 өрөө 14.2м2
8	МХС Архив өрөө 15.49м2
9	МХС Фитнесс өрөө
10	МХС ЛАЦ өрөө 143м2
11	МХС Техник өрөө
12	МХС Телевизионы өрөө
13	МЦХ EWSD өрөө
14	МЦХ Кросс өрөө 73.2м2
15	МЦХ ИТА өрөө
16	Монгол шуудан Дарга өрөө 18м2
17	Коридор-1 20.05м2
18	Коридор-2 40.42м2

0 давхрын план зураг



Тодорхойлолт	
1	МХС Склад-1 26.14м2
2	МХС Склад-2 22.57м2
3	Хоосон өрөө 85.34м2
4	Уурын зуух
5	Хоосон өрөө 56м2
6	Монгол шуудан архив 11.2м2
7	МХС Склад-4 11.2м2
8	МХС Склад-3 16.8м2
9	Хоосон өрөө 16.8м2
10	ШАХТ 10.4м2
11	Хонгил 31.9м2